



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2026-2030 ОН)**

Улаанбаатар хот
2026 он



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2026 оны 03 сарын 19 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

ШУА-ийн дунд хугацааны (2026-2030)
стратеги төлөвлөгөө батлах
тухай

Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 2,7,10 дугаар зүйл, Шинжлэх Ухааны Академийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Шинжлэх Ухааны Академийн дунд хугацааны (2026-2030) стратеги төлөвлөгөөг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:


1. Шинжлэх Ухааны Академийн дунд хугацааны (2026-2030) стратеги төлөвлөгөөг Тэргүүлэгч гишүүдийн саналыг тусган хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй шуурхай зохион байгуулж ажиллахыг Дэд ерөнхийлөгч (Б.Авид, Ц.Цэрэндорж), Эрдэмтэн нарийн бичгийн дарга (Ш.Ариунаа), Тэргүүлэгчдийн газрын дарга (А.Баярбаатар) нарт үүрэг болгосугай.
3. Стратеги төлөвлөгөөний мониторингийн зөвлөл байгуулж ажиллуулахыг ШУА-ийн ерөнхийлөгч (С.Дэмбэрэл)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ

С.ДЭМБЭРЭЛ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДОКТОР(Sc.D)

Ш.АРИУНАА



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	6
ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ	7
ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ	11
ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА	17
ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО	17
ЗУРГАА. ҮНЭТ ЗҮЙЛ	17
ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ	17
НАЙМ. ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ	19
ЕС. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	28



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи (ШУА) бол судалгаа, боловсруулалтын ажлыг үндэсний хэмжээнд нэгтгэн зохион байгуулах чиг үүрэг бүхий шинжлэх ухааны төв байгууллага юм. ШУА нь үндэсний шинжлэх ухааны чадавхыг улсын хөгжлийн гол хөшүүрэг болгон авч явах, нийгмээ соён гэгээрүүлэх, засгийн газарт зөвлөх байх, зорилтуудыг Их, Бага чуулган, харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтнуудынхаа үйл ажиллагаанд удирдлага болгон ажилладаг.

Аливаа тогтолцоо, тодорхой байгууллагын оршин тогтнож, тогтвортой хөгжих үндэс нь үйл ажиллагаагаа алсын болон дунд, ойрын ирээдүйд төлөвлөн, бодлого зорилтоо тодорхойлох явдал мөн. Ийм төлөвлөлтийн үндсэн нэг хэлбэр нь дунд хугацааны стратегийн төлөвлөгөө юм.

ШУА-ийн үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө (2026-2030)-г Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон “ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, ШУА-ийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээнд нийцүүлэн боловсруулав. Төлөвлөгөөг боловсруулахдаа төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримтлав.

Стратеги төлөвлөгөөнд 4 ерөнхий чиг үүргийн хүрээнд стратегийн 7 зорилт, 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгав.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

ШУА-д хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд Мандатын шинжилгээг хийж, дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		19	
Үүнээс:	Тухайн салбарын хууль	1.	Монгол Улсын Үндсэн хууль
		2.	Шинжлэх Ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хууль
		3.	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
	Нийтлэг мөрддөг хууль	1.	Инновацийн тухай хууль
		2.	Патентын тухай хууль
		3.	Оюуны өмчийн тухай хууль
		4.	Төсвийн тухай хууль
		5.	Төрийн албаны тухай хууль
		6.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
		7.	Төрийн хэмнэлтийн тухай хууль
		8.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
		9.	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
		10.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
		11.	Хөрөнгө оруулалтын тухай хууль
		12.	Шилэн дансны тухай хууль
		13.	Хөдөлмөрийн тухай хууль
		14.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль
15.	Авлигын эсрэг хууль		
16.	Холбогдох бусад хуулиуд		
Ерөнхий чиг үүрэг-1. ШУА-ийн менежментийн чадавхыг дээшлүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох			
Үндсэн чиг үүрэг		Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Менежментийн чадавхад суурилсан удирдлагын тогтолцоо, үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх		Байгууллагын менежментийн чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөртэй болж, тодорхой давтамжтай зохион байгуулах	Тэргүүлэгчдийн газар, Харьяа хүрээлэнгүүд
		Салбарын бүх байгууллагын хэмжээнд мөрдөх чанарын удирдлагын нэгдсэн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
		ШУА-ийн Их, Бага чуулганы үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, менежмент, манлайллыг эрчимжүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд



	Гүйцэтгэлд суурилсан удирдлагын тогтолцоог бэхжүүлэх	
2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	ШУА-ийн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, журмыг шинэчлэх, боловсронгуй болгох	УИХ, ЗГ, ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Салбарын хууль тогтоом, дүрэм журмыг шинэчлэх боловсронгуй болгоход оролцох	УИХ, ЗГ, ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	ШУА-ийн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах	Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
Ерөнхий чиг үүрэг-2. Үндэсний шинжлэх ухааны чадавхыг бэхжүүлж, суурь шинжлэх ухааны салбаруудын тогтвортой хөгжлийг ханган, технологийн тэргүүлэх чиглэлийг дэмжин, инновац болон нийгэм, эдийн засгийн өгөөжид суурилсан судалгааг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдлэгийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Үндэсний шинжлэх ухааны чадавхыг бэхжүүлж, суурь шинжлэх ухааны салбаруудын тогтвортой хөгжлийг хангах	Суурь шинжлэх ухааны урт хугацааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, тогтвортой дэмжих бодлого хэрэгжүүлэх	Харьяа хүрээлэнгүүд, их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд
	Суурь судалгаанд академик эрх чөлөө, судалгааны ёс зүй, чанарын үнэлгээний нэгдсэн стандартыг мөрдүүлэх	Харьяа хүрээлэнгүүд, их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд
	Суурь судалгааны хүний нөөцийн залгамж халаа, судалгааны ахисан түвшний сургууль, менторшипийн тогтолцоог төлөвшүүлэх	Харьяа хүрээлэнгүүд, их, дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагууд
2. Технологийн тэргүүлэх чиглэлд тулгуурласан, инновац болон нийгэм, эдийн засгийн өгөөжтэй судалгааг хөгжүүлэх	Суурь судалгаанд тулгуурласан хэрэглээний, туршилт-хөгжүүлэлтийн болон инновацын судалгааг тэргүүлэх чиглэлд төвлөрүүлэн хөгжүүлэх	ЭЗХЯ, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд
	Инновац, технологи дамжуулалт, патент, лиценз бүхий судалгааны бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх дэмжлэгийн механизмыг хэрэгжүүлэх	ЭЗХЯ, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд
	Судалгааны үр дүнг сайжруулах чиглэлээр төр-хувийн хэвшил-шинжлэх ухааны байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх	ЭЗХЯ, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд

3. Шинжлэх ухааны мэдлэгийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, бодлого, практикт нөлөөлөх чадавхыг нэмэгдүүлэх	Судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид, салбарын байгууллагуудад зориулсан шинжлэх ухаанд суурилсан зөвлөмж, бүтээгдэхүүн хэлбэрээр түгээх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Нээлттэй шинжлэх ухаан, нээлттэй өгөгдөл, олон нийтэд чиглэсэн шинжлэх ухааны харилцааг хөгжүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Шинжлэх ухааны соён гэгээрэл, олон нийтийн оролцоог дэмжсэн сургалт, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд, олон нийтийн байгууллагууд
Ерөнхий чиг үүрэг-3. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, залгамж халааг бэлтгэх менежментийг боловсронгуй болгох		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Хүний нөөцийн хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх	Хүний нөөцийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Чадавхжуулалт, тасралтгүй хөгжлийн тогтолцоог бүрдүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд,
	Гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх	СЯ, ЭЗХЯ, Хүрээлэнгүүд
	Хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн баталгааг дээшлүүлэх	ЭЗХЯ, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Чадварлаг хүний нөөцийг татах, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх	Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Залгамж халаа, менторшипийн тогтолцоог төлөвшүүлэх	Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи, Салбарын бага чуулганууд
	Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг шинэчлэх замаар дундаж цалинг өсгөх	Холбогдох яамд, Харьяа хүрээлэнгүүд, төрөлжсөн академи,



		Салбарын бага чуулганууд
Ерөнхий чиг үүрэг-4. Санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсронгуй болгох, олон эх үүсвэрт санхүүжилтийн механизмыг үе шаттайгаар хөгжүүлэх		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Бодлого, төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлж, ил тод, хариуцлагатай санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх	Үр дүнд суурилсан санхүүжилтийн бодлого, механизм боловсруулах	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд
	Улсын төсөв, гадаад болон дотоодын эх үүсвэрийг оновчтой төлөвлөх	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд
	Судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилтийг стратегийн зорилттой уялдуулах	Тэргүүлэгчдийн газар, харьяа хүрээлэнгүүд
	Гадаад, дотоодын төсөл, грант, гэрээт судалгааны санхүүжилтийг татах	ЭЗХЯ, Олон улсын байгууллагууд, гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгчид
	Судалгааны үр дүн, оюуны өмч, технологи дамжуулалтаас орлого бүрдүүлэх	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд
	Төр-хувийн хэвшлийн түншлэл, эндоумент сангийн тогтолцоог хөгжүүлэх	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд
	Лаборатори, тоног төхөөрөмж, судалгааны дэд бүтцэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг татах	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд
	Томоохон бүтээн байгуулалт, зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийг үйл ажиллагааг төвлөрүүлэх	Сангийн яам, ЭЗХЯ, харьяа хүрээлэнгүүд

ГУРАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

ШУА-ийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, цаашдын стратегийн чиглэлийг боловсруулах зорилгоор орчны шинжилгээ хийв.

Өнөөгийн байдал

ШУА нь Археологийн хүрээлэн, Биологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Газарзүй, геоэкологийн хүрээлэн, Геологийн хүрээлэн, Математик, тоон технологийн хүрээлэн, Одон орон, геофизикийн хүрээлэн, Олон улс судлалын хүрээлэн, Палеонтологийн хүрээлэн, Тархи, сэтгэл судлалын хүрээлэн, Технологийн инкубатор, Түүх, угсаатны зүйн хүрээлэн, Физик технологийн хүрээлэн, Философийн хүрээлэн, Хими, химийн технологийн хүрээлэн, Хэл зохиолын хүрээлэн гэсэн салбарын 16 хүрээлэн, ахисан түвшний нэг их сургуультай. Эдгээр харьяа байгууллагыг түшиглэн суурь болон хэрэглээний судалгаа хийх, шинжлэх ухааны бодлогыг дэмжих, мэдлэгийг түгээх, мэргэжилтэн бэлтгэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг явуулдаг.

ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний 16 хүрээлэнд нийт 1118 хүн ажиллаж байгаагаас 907 нь эрдэм шинжилгээний ажилтан байна. Үүний дотор академич 30, шинжлэх ухааны доктор (Sc.D) 19, доктор (Ph.D) 280 ажиллаж байгаа бөгөөд 35 хүртэлх насны залуучууд нийт эрдэм шинжилгээний ажилтны 37.9 хувь, 35-аас 50 насных 44.3 хувийг эзэлж, дундаж нас 42 байна. Эрдэм шинжилгээний ажилтны 35.7 хувь нь доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байгаа ба 2025 оны байдлаар 196 эрдэм шинжилгээний ажилтан докторантурт суралцаж байна. Энэ нь залуу судлаачдын эзлэх хувь боломжийн түвшинд байгаа боловч докторын зэрэгтэй ажилтны хувь, тогтворжилт, карьерын шатлалд бодлогын дэмжлэг шаардлагатайг харуулж байна.

Их чуулган

ШУА-ийн удирдах дээд байгууллага нь академийн бүх гишүүдийн Их чуулган юм. Их чуулган нь жилд хоёроос доошгүй удаа хуралдаж шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг хэлэлцэж, судалгааны тодорхой чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих, ШУА-ийн эрдэм шинжилгээ үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, Академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон эрдэмтэн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаагаар сонгох болон хуулиар заагдсан бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.

ШУА нь шинжлэх ухааны төв байгууллагын хувьд нэр хүндтэй эрдэмтдийг



гишүүн (академич)-ээр сонгон эгнээндээ нэгтгэж, эх орондоо шинжлэх ухаан, тэргүүний технологи хөгжүүлэх эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. ШУА нь одоогоор 58 академичтай, тэдний 48.3% ШУА-д, 51.7% их, сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж байна

Тэргүүлэгчид

Их чуулганы чөлөөт цагт ШУА-ийн өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, эрдэмтэн нарийн бичгийн дарга, тэргүүлэгч гишүүдээс бүрдсэн Академийн Тэргүүлэгчид удирддаг бөгөөд Академийн Тэргүүлэгчид ажлын албаараа (Тэргүүлэгчдийн газар) дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Бага чуулган, төрөлжсөн академи

Шинжлэх ухаан, технологийн бодлогыг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэл, цөм технологийн судалгааны ажилд эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл хамтын ажиллагааг хангах, эрдэмтдийг өргөнөөр оролцуулах, Шинжлэх ухаан, бизнесийн байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, эрдэм шинжилгээний бүтээл, дэвшилтэт технологийг хувийн хэвшлийнхэнд сурталчлан таниулах, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх зорилгоор ШУА-ийн салбарын 6 бага чуулган, мөн бүтцийн 2 төрөлжсөн академи нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн 352 эрдэмтний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр нь:

- Физик, математик, информатикийн салбарын бага чуулган
- Хими, биологийн салбарын бага чуулган
- Геологи, газарзүй, байгаль орчны салбарын бага чуулган
- Нийгмийн шинжлэх ухааны салбарын бага чуулган
- Хүмүүнлэгийн ухааны салбарын бага чуулган
- Техник, технологийн салбарын бага чуулган
- Монголын Анагаах ухааны академи
- Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи юм.

Салбарын бага чуулган, төрөлжсөн академиуд нь салбарынхаа судалгаа шинжилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, салбарын шинжлэх ухааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг дээшлүүлэх, шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс орны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, үндэслэл боловсруулах чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг.

Гадаад харилцаа

ШУА-ийн гадаад хамтын ажиллагаа бүс нутгийн түвшинд төдийгүй олон улсын хэмжээнд өргөжин тэлсээр ирсэн. ШУА нь уламжлалт харилцаа

бүхий орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны протокол, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр зарим орны ШУА, эрдэм шинжилгээний байгууллагатай харилцаа холбоо тогтоох, олон улсын чанартай арга хэмжээнд оролцох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, хамтарсан экспедиц ажиллуулах, эрдэмтэд солилцох зэрэг чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. ШУА нь Олон улсын шинжлэх ухааны зөвлөлийн жинхэнэ гишүүн бөгөөд дэлхийн 30 гаруй орны 100 гаруй эрдэм шинжилгээний байгууллага, их сургуультай хамтран ажиллаж, тэдгээртэй байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу эрдэмтэн солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Цаашид хамтын ажиллагааг тэргүүлэх чиглэлийн судалгаа, хамтарсан лаборатори, судлаач солилцоо, олон улсын санхүүжилт татах зорилготой уялдуулна.

Санхүү, хөрөнгө оруулалт

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 107 дугаар тогтоолоор ШУА-д харьяа хүрээлэнгүүдийнхээ төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрх олгосон нь шинжлэх ухааны байгууллагын хувьд санхүүгийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн чухал алхам болсон.

2025 оны байдлаар ШУА нь улсын төсвөөс 53.2 тэрбум төгрөгийн санхүүжилт авч, 14.8 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Эдгээр үзүүлэлтийг 2020 оныхтой харьцуулахад улсын төсвөөс авсан санхүүжилт 2.4 дахин, гэрээт ажил, төслийн орлого 2.2 дахин өссөн байна.

Судалгааны чиглэл, үр дүн

ШУА-ийн хүрээлэнгүүд нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарт Монголын төрт ёсны түүх, философи, эрх зүй, эдийн засаг, монгол хэл, ард түмний соёл уламжлал, орон судлал, иргэншил судлал, археологи, орчин үеийн улс төр судлал, социологи, байгалийн ухааны салбарт физик, математик, хими, Монгол орны геологи, ашигт малтмал, палеонтологи, биологийн нөөц, экологи, генетик, эрдсийн болон биологийн түүхий эд боловсруулах хими, биологийн технологи, нанотехнологи, электроник, эрчим хүч, газар хөдлөл, тоон болон сансрын технологийн чиглэлээр зонхилон ажиллаж байна.

Суурь судалгааны бүтээлийн 30 хүртэл хувийг гадаадын мэргэжлийн нэр хүндтэй сэтгүүлд болон олон улсын түвшинд хэвлүүлэх, оюуны бүтээл, патент, технологи, ТЭЗҮ-г эдийн засгийн эргэлтэд оруулах, бодлого боловсруулагчид, төр засаг, орон нутгийн байгууллагуудад санал, зөвлөмж өгч ажиллахыг эрмэлзэн ажиллаж байна.

АНУ-ын Clarivate Analytics компанийн Web of Science группийн мэдээллийн сангийн мэдээллээр Монгол улсаас гадаадын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлийн 28 хувь, Scopus мэдээллийн санд бүртгэлтэй Монголын судалгааны бүтээлүүдийн 37 хувийг ШУА-ийн эрдэмтэд тус тус гаргаад байна.



ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд суурь судалгааны төсөл 18, шинжлэх ухаан, технологийн төсөл 4, улсын захиалгат төсөл 18, цөм технологийн төсөл 1, Инновац, Технологийн туршилт, зүгшрүүлэлтийн төсөл 2, гадаадтай хамтарсан төсөл 55, грант төсөл 34, нийт 132 төсөл хэрэгжүүлснээс, 2025 онд 78 нь дууссан байна.

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдээс 2025 онд 528 эрдэм шинжилгээний өгүүллийг гадаадын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна. Үүнээс Скопуст бүртгэлтэй сэтгүүлүүдэд хэвлүүлсэн өгүүллийн тоо 387 байна.

ШУА-ийн харьяа хүрээлэнгийн судлаачид 2025 онд ном, нэг сэдэвт болон хамтын бүтээл 218, эрдэм шинжилгээний өгүүлэл 943 (гадаадад 528), эрдэм шинжилгээний илтгэл 1357 (гадаадад 533), нийт 2518 бүтээл хэвлэн нийтлүүлсэн байна.

Түүнчлэн шинжлэх ухааны хялбаршуулсан товхимол 15, нийтлэл, өгүүлэл 109, лекц 159, патент 13, стандарт 16, ТЭЗҮ 1, ашигтай загвар 3, технологийн загвар 7, аргачлал, гарын авлага 25, зөвлөмж 63, зураг, каталог 345, авран хамгаалах 109, лавлагааны материал 6, хээрийн судалгааны тайлан 378, социологийн тайлан 16-г гаргасан байна.

Инновацын тухай хууль, Компанийн тухай хууль, Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журмыг баримтлан ШУА-ийн харьяа хүрээлэнгийн дэргэд 7 гарааны компани байгуулагдсан бөгөөд 2025 оны байдлаар бойжих хугацаа нь дууссан 4, үйл ажиллагаа нь идэвхтэй 3 гарааны компани байна.

ШУА нь эрдэм шинжилгээний өгүүлэл, сэтгүүлүүдийн чанарыг дээшлүүлэх, олон улсын стандартын шаардлагад нийцүүлэх бодлого, зорилтын хүрээнд олон улсын INASP байгууллагын “Онлайн сэтгүүлүүд - Journals Online (JOLs)” төслийн дэмжлэгтэйгээр Монголын эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийн нэгдсэн платформ – Mongolia Journals Online (MongoliaJOL)-ийг 2011 оноос хойш хөгжүүлж байна. Үүний үр дүнд ШУА-ийн Хими, хими технологийн хүрээлэнгийн “Mongolian Journal of Chemistry” сэтгүүл нь олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлийн нэр хүнд бүхий Cite Score, SJR болон SNIP үнэлгээнүүд анх удаа хийгдэн улмаар Скопус (Scopus)-ын мэдээллийн санд бүртгэлтэй Монголын анхны сэтгүүл болоод байна. Тухайн платформд одоогоор 11 байгууллагын 30 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэгдсэн байгаа бөгөөд энэ онд шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан 9 сэтгүүлийг шинээр элсүүллээ. Эдгээр сэтгүүлд хэвлэгдсэн бүтээлийг 556,346 удаа татан уншиж, 1,489 удаа эшлэл авсан байна.

Шинжлэх ухааны ололтыг сурталчлах, нийгмийг соён гэгээрүүлэх хүрээнд: “Эрдэмтдийн үг” болон Академичдын цуврал лекц, “Эрдмийн аян”, “Шинжлэх ухааны наадам-Science festival”, “Нэг эрдэмтэн – нэг лекц” хөтөлбөр, “Дэлхийн шинжлэх ухааны өдөр” болон монголын “Шинжлэх ухааны ажилтны өдөр”-т зориулан ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн “Нээлттэй хаалганы өдөр” сарын аян, хүүхэд залуучууд, олон нийтэд зориулсан шинжлэх ухааны хялбаршуулсан цуврал ном хэвлүүлэх зэрэг олон арга хэмжээг уламжлал болгон хэрэгжүүлж байна.

Хүснэгт 2. Орчны шинжилгээ

Дотоод орчны шинжилгээ	
Давуу тал	Сул тал
• Үндэсний болон олон улсын хэмжээнд танигдсан, нэр хүндтэй, олон жил түүх, тогтвортой бүтэц, зохион байгуулалт бүхий шинжлэх ухааны ууган байгууллага. • Үйл ажиллагаа нь бие даасан хуулиар зохицуулагдсан шинжлэх ухааны бодлого тодорхойлоход оролцох үндэсний статустай. • Онолын, хэрэглээний, салбар дундын болон салбар дамнасан судалгаа хөгжүүлэлтийг дэмжин хэрэгжүүлэхэд тохиромжтой бүтэц, бүрэлдэхүүнтэй. • Салбар бүрийн туршлагатай эрдэмтэн, судлаачдын нөөцтэй, гадаадын олон арван эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны тогтсон сүлжээтэй, бодлого, үйл ажиллагааны залгамж чанар бүхий нэр хүндтэй. • Гадаад улс орон, бүс нутаг, дэлхийд танигдсан бүтээл ихтэй, оюуны өндөр чадамжтай эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтантай. • Улсын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх болон хөгжлийн бодлого тодорхойлоход эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтны үүрэг, оролцоо өсөн нэмэгдэж буй бөгөөд нийгмийг соён гэгээрүүлэх зохих туршлагатай. • Улсын төсвийн санхүүжилттэй, судалгаа, шинжилгээний ажлын зохих дэд бүтэц, нөөцтэй. • Олон улсын шинжлэх ухааны байгууллага, академийн гишүүнчлэл, хоёр болон олон талт хамтын ажиллагааны олон жилийн туршлагатай.	• Санхүүжилтийн хэмжээ бага, эх үүсвэр цөөн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн эзлэх хувь хангалтгүй. • Лабораторийн техник, тоног төхөөрөмжийн хангамж, шинэчлэлийн түвшин дэлхийн жишгээс доогуур, үүнд чиглэгдсэн хөрөнгө оруулалт хязгаарлагдмал учраас олон улсын түвшинд хүрсэн судалгааны лаборатори дутмаг. • Олон улсын түвшний өрсөлдөхүйц цалин, урамшуулал, судалгааны орчин бүрдээгүй. • Залуу эрдэм шинжилгээний ажилтнуудыг тогтоон барих урамшуулал, карьерын тогтолцоо сул, судалгааны чиглэл, үр дүн сонирхол татахуйц бус байгаа нь залуу эрдэмтдийг тогтвортой, урт хугацаанд ажиллуулахад хүндрэл үүсгэж, оюуны урсгал буюу “оюуны урсгал”-ыг нэмэгдүүлдэг. • Судалгаа, инновац, үйлдвэрлэлийн уялдаа сул. • Судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх явц удаан, инновацыг дэмжих санхүүгийн нөөц хязгаарлагдмал, эрдэмтэн-энтрэпренёр цөөн, • Судалгааны үр дүнг үйлдвэрлэл, бизнес дамжуулах дэд бүтэцгүй, үйлдвэрлэлд нэвтэрч байгаа патент, технологийн тоо цөөн. • Үндсэн болон тэргүүлэх судалгааны чиглэлийг хэт өргөн хүрээнд тодорхойлноос үүдэн зорилтот хугацаанд тодорхой үр дүнд хүрэх боломж хязгаарлагдсан.



Хүснэгт 2. Орчны шинжилгээ

Гадаад орчны шинжилгээ	
Боломж	Аюул, эрсдэл
• Шинжлэх ухаан технологийн салбарыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин зохих хэмжээнд бүрдсэн. • Төр засгийн зүгээс шинжлэх ухаан, технологийн салбарыг дэмжих талаар эерэг хандлага бий болж байгаа. • Төрийн бодлого боловсруулах үйл ажиллагаанд академийн Ерөнхийлөгч, Тэргүүлэгчид, Академичид, Их, Бага чуулганы гишүүд оролцох боломж хуулиар нээлттэй. • Шинжлэх ухаан, технологи, инновацыг эдийн засгийн өсөлтийн тулгуур болгох бодлогын чиг хандлага. • Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлоготой уялдуулах боломж. • Судалгааны үндсэн чиглэлийг тодорхойлох, бодлого боловсруулахад оролцох эрх зүйн суурьтай. • ШУА-ийн хэмжээнд цахим засаглалыг хэрэгжүүлэх дэд бүтэц, технологийн суурь боломж бүрдсэн. • Хувийн хэвшил дэх шинэ мэдлэг, технологи эрэлхийлэх хандлага өсөн нэмэгдэж байгаа. • Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр гадаад харилцаа сайтай. • Судалгааны үр дүнг патент, лиценз, стартап хэлбэрээр эдийн засгийн эргэлтэд оруулах боломж. • Судалгааны өгөгдөл, нээлттэй шинжлэх ухаан, хиймэл оюунд суурилсан судалгааг хөгжүүлэх боломж.	• Шинжлэх ухааны салбарт чиглэсэн төр, засгийн бодлого, хандлага, дэмжлэг тогтворгүй, тууштай бус. • Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд чиглэгдсэн төсвийн санхүүжилт хангалтгүй. • Судалгаа, боловсруулалтын ажлын төсөвт хүний нөөцийг хөгжүүлэх зардал тусгагддаггүй. • Эрдэм шинжилгээний хүрээлэнд магистр, докторын зэргийн сургалт явуулах эрхзүйн боломж хязгаарлагдмал. • Чадварлаг судлаачид гадаад руу шилжих, хувийн сектор руу татагдах хандлага. • Инновацын хуулийг хэрэгжүүлэх дагалдах журам, санхүүгийн механизм дутмаг. • Инновацыг дэмжих сан, венч сан байхгүй. • Шинжлэх ухаан, технологийн парк болон үйлдвэрлэлийн кластерийн хөгжил сул. • Үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын ажиллагаа сул. • Нэг сая хүнд ноогдох эрдэм шинжилгээний ажилтны тоогоор Азийн дунджаас 3 дахин бага, хүний нөөц хязгаарлагдмал. • Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо сул. • Эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны тогтворгүй байдал.

ДӨРӨВ. АЛСЫН ХАРАА

Шинжлэх ухаан, технологи, инновацад тулгуурласан нийгэм-эдийн засгийн хөгжлийн түүчээ байгууллага байна.

ТАВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Олон улсад нэр хүндтэй, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай, эх орондоо шинжлэх ухаан технологи инновацын салбарт манлайлагч байгууллага болно.

ЗУРГАА. ҮНЭТ ЗҮЙЛ

- Монголчуудын түүхэн хугацаандаа хуримтлуулсан эрдмийн баялаг сан
- Ёс суртахуунтай, бүтээлч сэтгэлгээтэй, чадварлаг эрдмийн эвсэг хамт олон
- Академик эрх чөлөө, ёс зүй, эх оронч төлөвшилд суурилсан шинжлэх ухаан, технологи инновацын цогц үйл ажиллагаа
- Улс орны нийгэм эдийн засгийн зангилаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эрдэмтэн, судлаачдын манлайлал

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ

Стратегийн төлөвлөгөөнд 2026-2030 онд ШУА, харьяа хүрээлэнгүүдийн хамт үндэсний тэргүүлэх эрдмийн байгууллагын сүлжээнээс олон улсын эрдмийн сүлжээнд өрсөлдөх чадвар бүхий тогтолцоо болох зорилтыг дараах стратегийн зорилтуудыг нэгтгэн тодорхойлов. Үүнд:

1. Шинжлэх Ухааны Академийн менежментийн чадавхыг дээшлүүлж, ил тод, хариуцлагатай, тогтвортой үндэсний шинжлэх ухааны байгууллагын тогтолцоог бүрдүүлэх.
2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шинжлэх ухаан, технологийн бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх.
3. Хязгаарлагдмал нөөцийг төвлөрүүлэх замаар инновац болон нийгэм, эдийн засгийн бодит өгөөжтэй, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэх чиглэлийн судалгааг хөгжүүлэх.
4. Урт хугацаанд шинжлэх ухааны суурь чадавхыг хадгалан хөгжүүлж,



үндэсний болон дэлхийн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулах суурь судалгааг хөгжүүлэх.

5. Судалгааны үр дүнг нийгэм, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого, практикт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх.

6. Шинжлэх ухааны академийн хүний нөөцийг олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, бүтээмж өндөр эрдэмтэн, судлаачид болгон төлөвшүүлэн хөгжүүлэх.

7. Шинжлэх ухааны академийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, олон эх үүсвэрт, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх.



НАЙМ. ЗОРИЛТЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Хүснэгт 3. Стратегийн зорилтыг хэмжих шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх арга зам

Стратегийн зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2025)	Зорилтот түвшин (2030)	Санхүүжилтийн хэмжээ /сая төгрөг/	Санхүүгийн эх үүсвэр
Ерөнхий чиг үүрэг 1. ШУА-ийн менежментийн чадавхыг дээшлүүлж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох						
Үндсэн чиг үүрэг 1. Менежментийн чадавхад суурилсан удирдлагын тогтолцоо, үр ашиг бүхий бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлэх						
1. ШУА-ийн менежментийн чадавхыг дээшлүүлж, ил тод, хариуцлагатай, тогтвортой үндэсний шинжлэх ухааны байгууллагын тогтолцоог бүрдүүлэх.	Монгол Улсын хөгжлийн тодорхойлох, хэрэгжүүлэхэд манлайлан оролцох	УИХ, ЗГ-т хүргүүлсэн санал, зөвлөмжийн тоо/хэрэгжилтийн хувь	$\geq 30/10\% \geq$	$\geq 50/ \geq 30\%$	-	Улсын төсөв
	ШУА болон харьяа хүрээлэнгүүдийн удирдлага, ажилтнуудад зориулсан хуул, эрх зүй, менежмент, манлайлын сургалт, семинарыг зохион байгуулах	Зохион байгуулсан сургалт, семинарын тоо	Тогтмол бус	Жилд ≥ 1	40.0	Улсын төсөв
	ШУА болон харьяа хүрээлэнгүүдийн менежментийн чадавхын үнэлгээ хийж, сайжруулах төлөвлөгөө боловсруулах	Үнэлгээ, төлөвлөгөө	Байхгүй	1	80.0	Улсын төсөв
	Дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг уялдуулах	Уялдан төлөвлөлтийн хувь	Тогтворгүй	100% уялдуулах	-	Улсын төсөв
	Төрийн болон орон нутгийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх	Хамтын ажиллагааны гэрээний тоо	10	≥ 20	-	Бусад эх үүсвэр
Ажлын чанар, үр дүнгийн үнэлгээнд суурилсан цалин, урамшууллын системийг нэвтрүүлэх		Хэрэгжилтийн хувь, үр дүн	Байхгүй	Бүрэн хэрэгжсэн	-	Улсын төсөв



Эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сангийн MORI платформог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх	MORI платформын технологи хөгжүүлэлт, баяжуулалтын хувь	30%	100%	8,000.0	Улсын төсөв
	Шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр олон улсын байгууллагуудад элсэх гишүүнчлэлээ нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх	Гиншүүнээр нь элссэн олон улсын байгууллагын тоо	8	15	Улсын төсөв, гадаад хамтын ажиллагааны сан
	Олон улсын байгууллагаатай хамтран ажиллах бодлого зохицуулалтын үйл ажиллагааг оновчтой болгон, төсөл хөтөлбөрийн тоог нэмэгдүүлэх	Хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо	12	30	Улсын төсөв, гадаад төсөл, донор байгууллага
Уламжлалт харилцаатай БНХАУ, ОХУ болон бусад улсын шинжлэх ухааны болон дээд боловсролын байгууллагаатай бүс нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаар шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх	Хоёр болон гурван талт судалгааны төсөл, хөтөлбөрийн тоо	6	18	1,500.0	Улсын төсөв, хоёр талт хэлэлцээр, олон улсын хөтөлбөр
	Үндсэн чиг үүрэг 2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэргжилтийг хангах				
	ШУА-ийн чиг үүрэг, үйл ажиллагаанд хамаарах хууль, дүрэм, журмыг шинэчлэх	Шинэчилсэн хууль, дүрэм журмын тоо	Хэсэгчилсэн	≥5 баримт бичиг	Улсын төсөв
2. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар шинжлэх ухаан, технологийн бодлогын хэргжилтийн үр нөлөөг нэмэгдүүлэх.	ШУА-ийн чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалттай холбоотой дотоод дүрэм, журмыг шинэчлэх, хууль тогтоомжид нийцүүлэх	Шинэчилсэн дүрэм журмын тоо	Хэсэгчилсэн	≥5 баримт бичиг	Улсын төсөв



	Харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлалыг боловсронгуй болгох	Батлагдсан шалгуур, аргачлалын тоо	0	1 багц шалгуур	60.0	Улсын төсөв
	Ёс зүйн дүрэм, хариуцлагын механизмдыг хэрэгжүүлэх	Урьдчилан сэргийлэх сургалтын тоо	Тогтмол бус	≥ 1	-	Улсын төсөв
	Төр-хувийн хэвшил-судалгааны байгууллагын хамтын ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Батлагдсан журмын тоо	0	1	-	Улсын төсөв
	Хүрээлэнгүүдийн өөрийн үйл ажиллагааны орлогыг захиран зарцуулахтай холбоотой эрхзүйн зохицуулалтын санал боловсруулах	Боловсруулсан журмын тоо/хэрэгжилтийн хувь	Байхгүй	1/100%	-	Улсын төсөв
Ерөнхий чиг үүрэг 2. Шинжлэх ухааны салбарын чадавхыг бэхжүүлж, тогтвортой хөгжлийг ханган, технологийн тэргүүлэх чиглэлийг дэмжих замаар инновац болон нийгэм, эдийн засгийн өгөөжид суурилсан судалгааг хөгжүүлэх, шинжлэх ухааны мэдлэгийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх.						
Үндсэн чиг үүрэг 1. Шинжлэх ухааны салбарын суурь чадавхыг бэхжүүлж, суурь шинжлэх ухааны салбаруудын тогтвортой хөгжлийг хангах						
1. Хязгаарлагдмал нөөцийг төвлөрүүлэх замаар инновац болон нийгэм, эдийн засгийн бодит өгөөжтэй, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий тэргүүлэх чиглэлийн судалгааг хөгжүүлэх	ШУА-ийн хэмжээнд хэрэгжиж байгаа судалгаа хөгжүүлэлтийн ажилд үнэлгээ хийж, инновац ба нийгэм, эдийн засгийн өгөөжид суурилсан тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, дэмжих	Батлагдсан тэргүүлэх чиглэлийн тоо	Байхгүй	5-7	15,000.0	Улсын төсөв
	Инженерчлэл, технологи, нэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн, нийгэм, эдийн засгийн салбарыг холбосон хэрэглээний болон салбар дундын судалгааг тэргүүлэх байдлаар хөгжүүлэх	Салбар дундын судалгааны төслийн тоо	Хэсэгчилсэн	≥ 40	40,000.0	Улсын төсөв
	Тэргүүлэх чиглэлийн судалгааг олон улсын хамтарсан төсөл, хөтөлбөр, судлаач солилцоо, хамтарсан экспедиц, лабораторитой уялдуулах	Олон улсын хамтарсан төслийн тоо	55	≥ 90	-	Улсын төсөв



Их дээд сургууль болон хувийн хэвшилтэй хамтарсан төсөл, хөтөлбөрийг нэмэгдүүлэх	Салбар дундын судалгааны хамтарсан лаборатори байгуулах	Хамтарсан төсөл, хөтөлбөрийн тоо	Хэсэгчилсэн	≥ 50	-	Улсын төсөв
	Нээлттэй шинжлэх ухааны зарчимд нийцсэн судалгааны өгөгдлийг түгээх, ашиглах бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх	Байгуулагдсан лабораторийн тоо	Хэсэгчилсэн	≥ 8	20,000.0	Улсын төсөв
	Тэргүүлэх чиглэлийн хүрээнд салбар дундын, өндөр чадавхтай судалгааны баг байгуулах	Батлагдсан бодлого, баримт бичгийн тоо	Байхгүй	1 багц	-	Улсын төсөв
	Инновац, технологи дамжуулалт, патентжих боломжтой судалгаанд зорилгот, өрсөлдөөнт санхүүжилт олгох	Байгуулагдсан баг, консорциумын тоо	Хэсэгчилсэн	≥ 10	1,000.0	Улсын төсөв
	Дижитал ур чадвартай судлаачдыг бий болгох, дижитал соёлыг байгууллагын түвшинд төлөвшүүлэх	Инновациад шилжсэн төслийн хувь	$< 10\%$	$\geq 30\%$	30,000.0	Улсын төсөв
	Орчин үеийн дижитал технологид суурилсан судалгааг хэрэгжүүлэх, хиймэл оюун ухаан, загварчлал, өгөгдлийн шинжилгээ, өндөр хүчин чадалын тооцоолол хийх чадавхыг үе шаттай нэвтрүүлэх	Сургалтад хамрагдсан эрдэм шинжилгээний ажилтны тоо	Тогтмол бус	≥ 500	100.0	Улсын төсөв
	Суурь болон хэрэглээний судалгааны төслийн эдийн засгийн үр ашиг, эрэлт, нийлүүлэлт, зах зээлийг тооцоолох багийг бүрдүүлж, үйлчилгээг үзүүлэх	Нэвтрүүлсэн технологийн тоо	Хэсэгчилсэн	≥ 5	-	Улсын төсөв
		Зөвлөх үйлчилгээ авсан төслийн тоо	Байхгүй	≥ 30	-	Улсын төсөв



Олон улсын өндөр зэрэглэлтэй мэргэжлийн ном, сэтгүүл, цахим платформын хангамж, ашиглалтыг сайжруулах	Хандалтын тоо	Хэсэгчилсэн	≥ 2 дахин өссөн	-	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 2. Технологийн тэргүүлэх чиглэлд тулгуурласан, инновац болон нийгэм, эдийн засгийн өгөөжтэй судалгааг хөгжүүлэх					
2. Урт хугацаанд шинжлэх ухааны салбарын суурь чадавхыг хадгалан хөгжүүлж, үндэсний болон дэлхийн шинжлэх ухааны хөгжилд хувь нэмэр оруулах суурь судалгааг хөгжүүлэх	Шинэ мэдлэг, шинэ үр дүн бий болгох суурь судалгааг тогтвортой эрчимжүүлэх	Дэмжсэн төслийн тоо	≥ 100	1,000.0	Улсын төсөв
	Бодлого, шийдвэр гаргахад чиглэсэн захиалгат судалгаа хийх механизмыг бий болгож, зөвлөмж, зөвлөх үйлчилгээг үзүүлэх	Захиалгат судалгааны тоо	≥ 30	-	Улсын төсөв
	Олон улсын импакт өндөртэй өгүүлэл, олон улсын патент бий болгохыг дэмжих замаар судалгааны чанар, бүтээлийн өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, урамшууллын механизмыг хэрэгжүүлэх	Импакт фактор бүхий өгүүлэл, патентын тоо	$\geq 150, \geq 10$	$\geq 300, \geq 20$	Улсын төсөв
	Судалгааны гүйцэтгэл, чанарын үнэлгээ, хянан магадлагаа, ил тод байдлыг сайжруулж KPI-д суурилсан нэвтрүүлэн үр дүнг бодлого, зах зээлд ойртуулах	Батлагдсан KPI, үнэлгээ	Тогтворгүй	-	Улсын төсөв
	Нийгмийн ухааны судалгааны чанарын шалгуур, үнэлгээний аргачлалыг тодорхой болгох	Батлагдсан аргачлал	Тогтворгүй	1 багц	Улсын төсөв
Үндсэн чиг үүрэг 3. Шинжлэх ухааны мэдлэгийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх, бодлого болон практикт нөлөөлөх чадавхыг нэмэгдүүлэх	Судалгааны академик эрх чөлөө, ёс зүйн хэм хэмжээг сайруулах	Хэрэгжилтийн түвшин	Тогтворгүй	Бүрэн хэрэгжсэн	Улсын төсөв
	Судалгааны үр дүнг бодлого боловсруулагчид, салбарын байгууллагад зориулсан зөвлөмж, бүтээгдэхүүн хэлбэрээр түгээх	Зөвлөмж, тайлангийн тоо	Тогтворгүй	≥ 20	Улсын төсөв
1. Судалгааны үр дүнг нийгэм, олон нийгэд					



түгээн дэлгэрүүлэх, бодлого, практикт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх	Нээлттэй шинжлэх ухаан, нээлттэй өгөгдөл, шинжлэх ухааны харилцааг хөгжүүлэх	Нээлттэй шинжлэх ухааны соён гэгээрлийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Нээлттэй өгөгдлийн багц	Байхгүй	≥ 10	-	Улсын төсөв
	Олон нийтэд чиглэсэн шинжлэх ухааны соён гэгээрлийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг нь шинэчлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	Байхгүй	≥ 30	200.0	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг нь шинэчлэх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг нь шинэчлэх	Шинэчилсэн журам, шалгуур	Байхгүй	1 багц	-	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг нь шинэчлэх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээлийг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага, шалгуур үзүүлэлтийг нь шинэчлэх	Индексжүүлсэн сэтгүүлийн тоо	Хэсэгчилсэн	≥ 5	-	Улсын төсөв
Ерөнхий чиг үүрэг 3. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, залгамж халааг бэлтгэх менежментийг боловсронгуй болгох							
Үндсэн чиг үүрэг 1. Хүний нөөцийг хөгжүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх							
1. ШУА-ийн хүний нөөцийг олон улсын түвшинд өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, бүтээмж өндөр эрдэмтэн, судлаачид болгон төлөвшүүлэн хөгжүүлэх	Хүний нөөцийн сургалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, мөрдүүлэх	Хүний нөөцийн сургалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг боловсруулж, мөрдүүлэх	Батлагдсан бодлого, төлөвлөгөө	Байхгүй	1 бодлого, 1 төлөвлөгөө	15.0	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжил, судалгааны чиглэл, насжилт залгамж халаанд суурилсан хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох	Эрдэм шинжилгээний ажилтны мэргэжил, судалгааны чиглэл, насжилт залгамж халаанд суурилсан хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох	ХН-ийн хэрэгцээний прогноз	Байхгүй	Жил бүр шинэчилдэг	-	Улсын төсөв
	Эрдэмтэн солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх	Эрдэмтэн солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх	Солилцоонд хамрагдсан эрдэм шинжилгээний ажилтны тоо	Хэсэгчилсэн	≥ 120 эрдэм шинжилгээний ажилтан	500.0	Улсын төсөв, ОУ төсөл
	Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах, ажиллах эрдэм	Гадаадын өндөр хөгжилтэй оронд суралцах, ажиллах эрдэм	Суралцсан эрдэм шинжилгээний ажилтны тоо	20 орчим	≥ 100	100.0	Улсын төсөв, грант



	шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлэх	Хамрагдсан эрдэм шинжилгээний ажилтны хувь	~10-15%	≥30%	-	Гадаад эх үүсвэр
	Гадаадын төсөл хөтөлбөрт хамрагдах эрдэм шинжилгээний ажилтны эзлэх хувийг нэмэгдүүлэх	Ашиглалтад орсон платформ	Байхгүй	1 платформ	1,000.0	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан цахим сургалтын платформыг хөгжүүлэх	Сургалтад хамрагдсан тоо	Тогтмол бус	Жилд ≥200	-	Улсын төсөв
	Ахисан түвшний сургалтад хамрагдах судлаачдын тоог нэмэгдүүлэх	Олгосон грантын тоо	10-15	Жилд ≥20	1,000.0	Улсын төсөв
	Залуу эрдэм шинжилгээний ажилтанд олгох судалгааны грантын тоог нэмэгдүүлэх	Дэмжлэг авсан эрдэм шинжилгээний ажилтны тоо	Хэсэгчилсэн	≥300	-	Улсын төсөв
	Судалгааны үр дүнг олон улсын сэтгүүлд хэвлүүлэхэд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Цалингийн өсөлтийн хувь	Засгийн газрын 238 дугаар тогтоол	≥30%	-	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг шинэчлэх	Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо	Байхгүй	≥250	-	Улсын төсөв, Төр хувийн хэвшлийн туншлэл, бусад
	Салбарын ажилтан, албан хаагчдад зориулсан орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх	Батлагдсан аргачлал	Байхгүй	1 багц	50.0	Улсын төсөв
	Эрдэм шинжилгээний ажилтныг үнэлэх үнэлгээний шалгуур, аргачлал боловсруулах	Сургалтад хамрагдсан тоо	Байхгүй	≥50	100.0	Улсын төсөв
	Өгөгдөлд суурилсан судалгаанд оролцох эрдэм шинжилгээний ажилтнуудад зориулсан ёс зүй, мэдээллийн хамгаалалт, өгөгдлийн удирдлагын чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах.					



Мэдлэг, чадвар, бүтээмжийн үнэлгээг урамшуулалтай уялдуулах	Гүйцэтгэлд суурилсан урамшуулал	Байхгүй	Бүрэн хэрэгжсэн	-	Улсын төсөв
Ерөнхий чиг үүрэг 4. Санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг боловсронгуй болгох, олон эх үүсвэрт санхүүжилтийн механизмыг үе шаттайгаар хөгжүүлэх					
Үндсэн чиг үүрэг 1. Боллого, төлөвлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлж, ил тод, хариуцагатай санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх					
1. ШУА-ийн санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, олон эх үүсвэрт, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх	Санхүү, хөрөнгө оруулалтын бодлого, дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх	Батлагдсан боллого, төлөвлөгөөний тоо	Байхгүй	Дунд хугацааны төлөвлөгөө батлагдаж, бүрэн хэрэгжсэн байна.	Улсын төсөв
	Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжих санал боловсруулах	Боловсруулж батлуулсан саналын тоо	Байхгүй	Боллогын баримт бичиг батлагдаж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо нэвтрэсэн байна.	Улсын төсөв
				100.0	Улсын төсөв
	Олон эх үүсвэрт санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх	Санхүүжилтийн эх үүсвэрийн тоо, түүний өсөлт	3-4 эх үүсвэр	6-8 эх үүсвэр	Улсын төсөв, гадаадын төсөл
	Гадаадтай хамтарсан, төсөл, хөтөлбөр, тэдгээрийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	Гадаадын төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлсэн төслийн тоо, санхүүжилтийн хэмжээ	48 төсөл	≥80 төсөл	Улсын төсөв, олон улсын байгууллага
	Улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх	Батлагдсан төсвийн өсөлт, үр дүн	65.9 тэрбум ₮	≥200 тэрбум ₮	Улсын төсөв
	Улсын хөрөнгөөр хэрэгжих томоохон төсөл, хөтөлбөрийн судалгааг эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлэх эрхзүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулах	Боловсруулсан санал, зөвлөмжийн тоо	Байхгүй	Эрхзүйн орчин бүрдсэн байна.	Улсын төсөв
	Төр, хувийн хэвшлийн оролцоотой хуримтлалын “Эндаумент (хуримтлалын)” сан байгуулах	Байгуулагдсан сан, хуримтлал	Байхгүй	Сан байгуулж, ≥2 тэрбум ₮ хуримтлалтай	Улсын төсөв, өөрийн орлого, бусад



	Судалгааны ажлын үр дүн, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах	Технологи дамжуулалтын орлогын хэмжээ	Тогтворгүй	Жил бүр өслөг тогтолцоо	-	Өөрийн орлого
	Харьяа хүрээлэнгүүдийн төсвийн бус орлогыг тогтвортой нэмэгдүүлэх	Орлогын өсөлт	15.5 тэрбум ₮	≥60 тэрбум ₮	-	Өөрийн орлого
	Томоохон зорилтыг шийдвэрлэхэд гадаадын төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг төвлөрүүлэх	Төвлөрсөн төслийн тоо	Тогтмол бус	Жилд ≥3 том төсөл	-	Гадаад эх үүсвэр
	Судалгааны тоног төхөөрөмжийн татварын хөнгөлөлтийн талаар бодлогын санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх	Баглагдсан журам	Байхгүй	Журам батлагдсан	-	Улсын төсөв
	Гадаадын зээл, тусламжаар лаборатори шинэчлэх, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх	Шинэчлэгдсэн лабораторийн тоо	Байхгүй	≥5 лаборатори	-	Олон улсын зээл, тусламж



ЕС. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хэлтсүүд стратеги төлөвлөгөөний өөрийн хэсэгт хамаарах шалгуур үзүүлэлт бүрийн хэрэгжилтийн явцыг жил бүрийн эцэст суурь түвшинтэй харьцуулан үнэлж, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн түвшинд дүн шинжилгээ хийнэ.

Хэрэгжилт хангалтгүй, саатсан, эсхүл дутуу хэрэгжиж буй ажлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлон, засаж сайжруулах арга хэмжээний санал боловсруулан ШУА-ийн удирдлагад танилцуулна.

Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлснээр санхүүжилтийн хязгаарлалт, хүний нөөцийн тогтворгүй байдал, судалгааны дэд бүтцийн хүрэлцээ, гадаад орчны өөрчлөлт зэрэг үүсэж болох эрсдэлийг урьдчилан тодорхойлно.

Эдгээр эрсдэлийг бууруулах зорилгоор санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого боловсруулж баримтлах, судалгааны орчин, нөхцөлийг сайжруулах, гадаад болон хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар шаардлагатай зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

-- ооо О ооо --